

## Чуулган бид хоёр

Сара Дийкс



Ерөнхий чуулганы бямба, ням гараг уйтгартай, урт юм надад санагддаг байж билээ. Гэвч цаг хугацаа өнгөрөх тусам би чуулганы өдрүүдэд дуртай болж, тэсч ядан хүлээдэг болсон. Ерөнхий чуулганы бямба, ням гарагт бид сүнслэг байдлын хувьд дахин цэнэглэгддэг ч энэхүү мэдрэмж нь даваа гаригт амьдрал хэвийн байдлаар үргэлжлэх үед алга болж бүдгэрэх нь амархан байдаг. Чуулганаас аль болох их зүйлийг сурч мэдэхэд надад дараах хэдэн санаа тусалсан юм.

Би чуулганд бэлтгэхдээ асуух асуултуудаа бичиж, дараа нь эдгээр асуултууд хэрхэн хариулагдсан талаар тэмдэглэл хөтөлдөг. Тэгээд чуулган дээр хэлсэн үгсээс болон чуулганы дуу хөгжмөөс ажлаа хийх явцдаа өдөр бүр нэг хэлсэн үг эсвэл нэг дуулал сонсож байхын тулд тэдгээрийг LDS.org-аас та-таж, MP3 тоглуулагч дээр хуулж авдаг.

Мөн би *Лиахона* сэтгүүлийн чуулганы дугаарыг уншиж судлах дуртай. Онцгой сонирхол татсан хэсгүүдийг тодруулан тэмдэглэхийн хамт сэтгүүлийнхээ хуудасны захад тэмдэглэл хийдэг. Дараагийн чуулган хүртэл би сэтгүүлээ маш сайн ашигладаг бөгөөд манай гэрийнхэн Лиахонагийн захиасуудыг заримдаа гэр бүлийн үдшээр хамтдаа судалдаг.

Бид чуулганы үеэр мэдэрсэн сүнсийг удаан хугацаанд хадгалж, захиасуудаас үргэлжлүүлэн суралцахын тулд хөдөлмөрлөх шаардлагатай ч энэ нь надад агуу адислал авчирдаг билээ. Би Ерөнхий чуулганы захиасуудаас судалснаар шаардлагатай үед маш их хүч чадал ба удирдамжийг хүлээн авдаг. Мөн эдгээр захиасууд нь сүнслэгээр нөлөөлөгддөг гэдгийг би мэднэ. *Зохиогч нь Канадын Торонтод амьдардаг.*

## ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

### Зангуугаа бөхөл

Ямар зүйл та нарыг сайн мэдээнд бат бөх итгэлтэй болгох вэ? Хөвгүүний гар дахь уяанаас зангуугаа бөхлөх найдвартай газрууд хэмээн ерөнхийлөгч Угдорфын хэлсэн зүйлс рүү шугам тат.

